

ЭКОЛОГИЙН НИЙТЛЭЛИЙН ГАРЧИГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ

ц.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: гарчиг, экологийн нийтлэл, гарчгийн хэлбэрүүд, үүрэг, зорилго, гарчигт тавигдах шаардлагууд, экологийн нийтлэлийн гарчгийн онцлог, нийгэм дэх идэвхтэй байр суурь.

Хүн бүр дуудуулах нэртэй байдаг шиг сонины нийтлэл болгон өөрийн гарчигтай байдаг. Төвд гаралтай «гарчиг» хэмээх үгийг Я.Цэвэл «Монгол хэлний товч тайлбар толь»-д «Ном хэвлэл, бичиг зохиолын дотор багтаж орсон зүйлийн хураангуй товъёг» гэж тайлбарласан нь бий¹.

Сонин хэвлэлийн ажилтан, сэтгүүлч, идэвхтэн бичигчид гарчгийн ач холбогдлыг өндөр үнэлж, нийтлэлээс илүүд үзэх нь цөөнгүй. Гарчиг бол нийтлэлийн үүд хаалга гэж ойлгож болно. Айлд үүд хаалгаар нь ордог шиг, сонины нийтлэлийг гарчгаар нь дамжин уншдаг. Аль ч гарчгийг уншигчийн сонирхол татахуйц хэмжээнд бодож, боловсруулах ёстой. Учир нь сонин хэвлэлийг худалдан авагч юуны түрүүнд «гарчиглаж» үздэг.

Орчин үеийн сонин хэвлэлийг гарчиггүйгээр төсөөлөхөд бэрх. Сонины дугаарт нийтлэгдсэн материалуудаас өөрт

хамгийн хэрэгтэй, хамгийн сонирхолтойг сонгоход гарчиг тусалдаг. Тийм ч учир гарчгийг И.Дамбажав, Л.Зундуй нар «уншигчдыг сонин сэтгүүлийн агуулга руу хандуулах чигийг заах луужин»² гэж оновчтой тодорхойлсон байдаг. Иймээс гарчгийг зүгээр нэг нэр төдий үзэх нь учир дутагдалтай.

Америкийн судлаач Р.Бардын бичсэнээр: «Гарчиг бол нийтлэлийн агуулгыг базсан товч дүгнэлт юм»³.

А.Н.Кулаковын үзэж буйгаар, гарчиг бол нэгж баримтыг тусгасан мэдээлэл юм⁴. «Справочник журналиста» лавлахад гарчгийг «материалын гол санаа, агуулгын маш товч, оновчтой илэрхийлэл» гэж тодорхойлжээ⁵.

Гарчиг бол бидний үзэж буйгаар, нийтлэлийнхээ агуулгыг ямар нэг хэмжээгээр илэрхийлсэн, уншигчийн сонирхлыг татахуйц товч мэдээлэл юм.

Ер нь гарчгийн тодорхойлолтод чөлөөтэй хандах нь зөв. Дээрх тодорхойлолтуудыг хүлээн зөвшөөрөхөд дутагдалтай зүйл бий. Учир нь гарчиг заавал нэгж баримтыг тусгадаггүй, заавал агуулгын маш товч, оновчтой илэрхийлэл байдаггүй. Манай өнөөгийн хэвлэлд

оновчгүй гарчиг оновчтойгоосоо илүү буй, мөн гарчиг сунжрах хандлагатай байгааг дурдалгүй өнгөрч болохгүй.

Сэтгүүл зүйн ямар ч сурах бичгийг аваад үзэхэд гарчиг бол нийтлэлийнхээ гол агуулгыг илэрхийлсэн мэдээлэл гэж тодорхойлсон байдагтай таарч болно. Гэтэл тогтмол хэвлэлийн гарчгийг судлахад нийтлэлийнхээ гол агуулгыг илэрхийлэх нь байтугай материалд огт дурдагдаагүй санаа агуулсан байх нь олонтаа тохиолддог. Тиймээс гарчиг бол нийтлэлийнхээ агуулгыг ямар нэг хэмжээгээр илэрхийлсэн товч мэдээлэл гэж бид тодотголоо.

Бусад сэдвээр бичигдсэн нийтлэлийн нэг адил экологийн материалын нэг чухал хэсэг бол гарчиг юм. Байгаль орчны асуудлыг тусгасан нийтлэлдээ оновчтой, сайн гарчиг өгөхийн тулд сэтгүүлч хэд хэдэн зүйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй:

— Нийтлэлийн гол санааг базаж гаргах,

— Асуудлын мөн чанар, онцлогийг харуулах,

— Асуудлын цар хүрээг харуулах,

— Төлөв байдлыг дүрслэх,

— Шалтгаан—үр дагаварыг гаргах,

— Зөрчлийг харуулах.

Эдгээрийг тодорхой жишээн дээр үзье. Нийтлэлийн гол санааг базаж тоймлох нь хэдийгээр мэдээнд илүү тохиромжтой ч экологийн материалд зохих нь бий. Тухайлбал: «Тас шувууны чихмэл хийдэг хүмүүсийг саатуулжээ» («Өдрийн сонин», 2008.03.15), «Хотын утаа хорт хавдар үүсгэх бодисыг их хэмжээгээр агуулдаг» («Өдрийн сонин», 2008.01.15), «Хүчтэй цөлжиж буй дэлхий

11 оронд Монгол орлоо» («Өнөөдөр», 2008.04.30) г. м.

Асуудлын мөн чанар, онцлогийг харуулах нь экологийн сэдэвт нийтлэлийн гарчгийн нэг үүрэг юм. Тухайлбал: «Атаршсан газар хагална гэдэг атрыг хагалснаас илүү хортой» («Өдрийн сонин», 2008.05.03), «Гялгар уут байгальд төдийгүй, хүний биед хортой» («Өдрийн сонин», 2008.05.30), «Гумат нь ургамлын тэсвэрлэх чанарыг дээшлүүлж, ургац нэмэгдүүлдэг» («Өдрийн сонин», 2008.06.06), «Баавгай аймхай, бас унтаахай» («Өнөөдөр», 2008.02.14) г. м.

Асуудлын цар хүрээг харуулах нь уншигчдад цэгц ойлголт өгөх давуу талтай. 2007 онд ой хээрийн түймэр 228 удаа гарч, 1,3 сая га талбай шатаж, улс оронд олон тэрбум төгрөгийн хохирол учирсан тухай сурвалжлагыг сэтгүүлч М.Мөнхцэцэг «Экологид учирсан хохирол 998 айлын орон сууцтай тэмцэнэ» («Өдрийн сонин», 2008.01.24) гэж гарчглажээ. Асуудлын үр дүнг харуулсан гарчиг энэ төрөлд хамаарна. Тухайлбал: «Түймэр есөн тэрбум төгрөгийн хохирол учрууллаа» («Өдрийн сонин», 2008.06.10) г. м.

Төлөв байдлыг дүрслэх нь байгаль орчинд тулгарсан асуудал даамжирч, түүнийг шийдвэрлэлгүй удвал ямар аюул тохиох магадлалтайг харуулдагаараа ач холбогдолтой. Тухайлбал: «Нийслэлд ундны усны хомсдол бий болох нь» («Өдрийн сонин», 2008.01.03), «Нийслэлчүүд шохойтой ус ууж, хорт хавдраар өвчлөх аюул нүүрлэлээ» («Өдрийн сонин», 2008.03.04), «Хуурайшилт ихэсч түймэр нэмэгдэх хандлага-

тай байна» («Өдрийн сонин», 2008.04.15)
г. м.

Шалтгаан—үр дагаварыг гаргах нь төлөв байдлыг дүрслэхтэй адил боловч биднийг отон хүлээж буй экологийн аюулыг чухам ямар хүчин зүйл бий болгосон талаар уншигчдад ач холбогдол өгдгөөрөө давуу талтай. Ийм гарчгаас жишээ татвал: «Бохир усны шугам хөлдсөнөөс болж Сэлэнгэ мөрөн бохирдож байна»

(«Өдрийн сонин», 2008.03.25), «Бүх малын 40%-ийг ямаа эзэлж байгаа нь бэлчээрийн хомсдолд оруулж байна» («Өдрийн сонин», 2008.04.04)
г. м.

Аливаа зөрчил хүний анхаарлыг ямагт татдаг. Тэрхүү зөрчил нь өчүүхэн зүйл ч байж болно. Олон талын ашиг сонирхлыг хөндсөн зөрчил бол тэр тусмаа сонирхол татна. Тухайлбал: «Хөрөнгө хүч гаргаж мод тарьсан газарт нь байшин барихаар болжээ» («Өдрийн сонин», 2008.05.30), «Ойн хамгаалагч нь модны хулгайчтай гар нийлжээ» («Өдрийн сонин», 2008.12.04), «Байгаль хамгаалах төрийн бодлого яаманд байхгүй байдаг» («Өдрийн сонин», 2008.12.12) г. м.

Экологийн нийтлэл ихэвчлэн ямар нэг асуудал дэвшүүлж байдаг учир мэдээлсэн гарчиг зохимжгүй байдаг. Тухайлбал:

«Хээрийн хэрээ» («Өдрийн сонин», 2008.01.07), «Бааст голын тухай» («Өдрийн сонин», 2008.01.04) зэрэг гарчиг сул болжээ. Харин уран нийтлэлийн хувьд өөр хэрэг. Мэдээлсэн, задлан шинжлэлт төрлөөр бус, нийтлэл-уран сайхны төрлөөр туурвигдсан материал ийм гарчигтай байвал буруутгах аргагүй. Энд Л.Батцэнгэлийн «Урсгал Эгдээ дуутай, уртхан Онондоо

цуутай Батширээт» («Өдрийн сонин», 2008.04.07), Х.Энх-туяагийн «Хайрхан уулын бараа» («Өдрийн сонин», 2008.-04.15), Ц.Доржсэм-бийн «Миний Өлзийт» («Өдрийн сонин», 2008.05.22) зэрэг уран нийтлэл, аян замын тэмдэглэлийг дурдаж болно.

Дээрхийн зэрэгцээ экологийн сэдэвт нийтлэлийн

гарчигт хэд хэдэн түгээмэл дутагдал ажиглагдаж байна.

Экологийн сэтгүүл зүйн нэг онцлог шинж нь нийгэм дэх идэвхтэй байр суурь болох тухай дээр дурдсан. Тэгвэл сэтгүүлч нь мэдээлэгч бус, харин хөндлөнгийн үгийг дамжуулагч, идэвхгүй зуучлагчийн байр сууринаас хандсан «гэнэ», «гэв» зэрэг үгээр төгссөн гарчиг сүүлийн үед олшрох хандлагатай болжээ. «Өдрийн сонин»-ы зөвхөн 2008 оны 3-5-р сарын дугаарт нийтлэгдсэн экологийн сэдэвтэй материалын гарчгийг аваад үзвэл:

«

Байгаль орчны асуудлыг тусгасан нийтлэлдээ оновчтой, сайн гарчиг өгөхийн тулд сэтгүүлч хэд хэдэн зүйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй:

— *Нийтлэлийн гол санааг базаагч гаргах,*

— *Асуудлын мөн чанар, онцлогийг харуулах,*

— *Асуудлын цар хүрээг харуулах,*

— *Төлөв байдлыг дүрслэх,*

— *Шалтгаан—үр дагаварыг гаргах,*

— *Зорчлийг харуулах.*

«Азийн орнуудын цэвэр усны нөөц 10 жилийн дараа дуусна гэв» (3-р сарын 19), «Алдаатай шийдвэр Монголыг элсэн цөл болгоно гэв» (4-р сарын 18), «Ан агнуурын тухай хуулийг өөрчилнө гэв» (4-р сарын 23), «Үүл буудвал түймэр унтрах боломжтой гэв» (4-р сарын 29), «Сайн дураараа түймэр унтраах 25 хүн байна гэв» (5-р сарын 10), «Онги голыг хамгаалах зэвсэгт тэмцэл хийнэ гэв» (5-р сарын 27), «Өдийд цас орох нь ховор үзэгдэл биш гэнэ» (5-р сарын 29) г. м.

Экологийн асуудал бол дэлхий нийтийн асуудал. Угаасаа байгаль орчинд хил хязгаар гэж үгүй. Тийм ч учир экологийн сэтгүүл зүй бол даяар сэтгүүл зүй юм. Ийм нөхцөлд орон нутгийн шинж чанар, цар хүрээтэй ч хамаагүй экологийн асуудлыг өөрт огт холбогдолгүй, хамааралгүй мэтээр «зайнаас» мэдээлэх нь буруу.

Бичиж буй зүйлээ хэт дөвийлгөх нь сэтгүүлчдэд ажиглагддаг түгээмэл дутагдлын нэг юм. «Монголд химийн дайн үргэлжилж байна гэлтэй» («Өдрийн сонин», 2008.04.15) гарчгийг аваад үзье. Нэг үе бүхэл бүтэн сумын иргэд мөнгөн усанд хордож, химийн хортой бодис айлаас торх торхоороо илэрч байсныг бодвол тийм ч оргүй худал зүйлийн тухай гарчиг биш гэлтэй. Гэхдээ «химийн дайн» гэдэг нэр томъёог аваад үзвэл хэт дэгсдүүлсэн нь тодорхой. Үүнийгээ ч сэтгүүлч мэдэж байсан мэт гарчгаа гэлтэй гэж төгсгөжээ.

«Химийн дайн» хэмээх нэр томъёог нэвтэрхий толиудад хэрхэн тайлбарласан байдгийг үзье. Онлайн «Шинжлэх ухаан, техникийн нэвтэрхий толь»-д «Химийн дайн бол хордуулах, мэдрэлийг

саажуулах хий зэрэг химийн зэвсгийг ашигласан байлдааны ажиллагаа» гэж тайлбарласан нь бий. 1961-1973 онд Вьетнамын дайны үеэр АНУ тус улсын байгалийн эсрэг химийн зэвсэг, тэр дотор дефолиант (аливаа ургамлын навчисыг унагаадаг бодис), гербицид (ургамлыг устгадаг бодис) зэрэг химийн бодисыг өргөн хэрэглэж байсан учир энэ дайныг мөн Экологийн дайн гэж нэрлэдэг.

Э нэхүү химийн дайны экологийн үр дагавар нь юу байв? Мангрийн ой (500 мянган га) бараг тэр чигээрээ устгаж, ширэнгэн ойн 60%, тал газрын ойн 30% (бараг 100 мянган га) химийн бодист хорджээ. 1960 оноос каучукийн ургац 75%-иар унасан байна. Мөн гадил, цагаан будаа, амтат төмс, улаан лооль, папайн ургацын 40-өөс 100%, наргил модны 70% устжээ. Энэ бол экологийн үр дагаварын зөвхөн нэгээхэн хэсэг. Энэ бүхний үр дүнд Вьетнамын экологийн тэнцвэрт байдал алдагджээ. Хордсон газар нутагт амьдарч байсан 150 зүйл шувуунаас 18 нь л үлдэж, хоёр нутагт амьтан, шавьжууд бараг тэр чигээрээ устаж, загас жараахай огцом цөөрсөн юм. Хөрсний микробиологийн бүтэц алдагдаж, мод, бут, ургамлын төрөл эрс цөөрч, малд тэжээл болохгүй өргөстэй хэдэн өвс л үлджээ.

Түүнчлэн хар хархны нэг төрлийг Өмнөд болон Зүүн-Өмнөд Азид тахал тараадаг өөр төрлийн хархнууд шахан зайлуулж, мөн аюултай өвчин тараадаг хувалзнууд дэлгэрсэн байна. Гэм хоргүй шумуулын оронд хүртэл хумхаа тараадаг шумуул гарчээ.

Тэгэхээр өөрийн мэдэхгүй нэр томъёог хамаагүй ашиглахаас сэтгүүлч аль болох зайлсхийж байх хэрэгтэй.

Гарчгийн асуудалдаа эргэн очъё.

Цэцэрхэх тохиолдол цөөнгүй гарч буй нь мөн л экологийн сэтгүүл зүйн үүрэг, зорилгод харш юм. «Улаанбаатарын уушиг устжээ» («Зууны мэдээ», 2008.02.12) гарчгийг уншихад сэтгүүлч юуны тухай хэлэх гэснийг таамаглаж болно. Гэхдээ агаарын бохирдлоос болж нийслэлчүүд уушигны өвчтэй болж байгааг ингэж хэлэх хэр оновчтой вэ? «Загаснууд дахин “амиа хорлов”» («Зууны мэдээ», 2008.04.03) гарчиг дэндүү ёс зүйгүй болжээ. *Амиа хорлов* гэдэг үгийг хашилтанд хийж ёжлох шаардлага бий юу? гэдгийг сэтгүүлч төдийгүй, редакци бодолцох ёстой байсан. Оросын судлаач Л.А.Кохановагийн оновчтой тэмдэглэснээр: «Сэтгүүлч мэдээлэл цуглуулахаар гараад хөдөө аж ахуйн салбарын ажилтантай ч, усны салбарын төлөөлөгчтэй ч өөрсдийнх нь ярьдаг тус тусын хэлээр харилцаж чадахгүй бол түүний нийтлэл сонины хуудаснаа хэвлэгдээд гараад ирвэл энэ нь ганц түүний төдийгүй, тухайн дугаарыг бэлтгэсэн хамт олны хариуцлага мөн. Тиймээс нэр томъёо, гарчигт гарсан болон ... бусад алдаа мэдгийн хариуцлагыг тухайн хэвлэлийн сэтгүүлчдийн бүхий л хамт олон адилхан үүрэх ёстой»⁶.

Дээрх гарчгийн үйл үгийн хэвийг анхаарах хэрэгтэй. *Амиа хорлох* гэдэг нь өөрөө үлдэх хэв. Тэгвэл загас өөрөө өөрийгөө егүүтгэсэн хэрэг үү? Аль эсвэл хүний буруутай үйл ажиллагаанаас

болж, тодруулбал гадны нөлөөгөөр өөрийн жам ёсны орчиндоо үхсэн үү?

Экологийн нийтлэлийн нэг зорилго нь асуудлыг дүрслэхэд төдийгүй, түүнээс гарах арга замыг тусгахад оршино. Экологийн сэтгүүлч бол зовлон тоочдог мэргэжил биш. Тиймээс аргаа барсан маягтай гарчгаас зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал: «Дархан цаазат газар буусан айлуудыг яах вэ» («Зууны мэдээ», 2008.02.07), «Дахиад л мөнгөн ус...» («Зууны мэдээ», 2008.04.07), «Сэлбэ голоо сүүлчийн замд нь үдье дээ» («Өнөөдөр», 2008.06.18) мэтийн цөхрөнгөө барсан гарчиг экологийн нийтлэлд зохимжгүй.

Экологийн асуудлыг хөндсөн материалуудад «Хятадын сэдэв» гэгч баттай байр суурь эзэлжээ. Зөвхөн «Зууны мэдээ» сонинд 2008 онд нийтлэгдсэн экологийн сэдэвтэй материалуудын гарчгийг сонирхъё: «Хонгорыг хордуулсан Хятадуудын хэрэг юу болсон бэ?» (2008.03.24), «Мөнгөн ус асгасан Хятадуудын мэдүүлэг зөржээ» (2008.03.25), «Хятадууд аккумуляторын шингэн асгажээ» (2008.03.28), «Монголын уул уурхайд бэлдсэн Хятадын өгөөш» (2008.05.20), «Монгол самранд Хятадууд яагаад шунах болов?» (2008.10.08), «Хятадууд дураараа авирлаж хөл бөмбөгийн талбайгүй болгох нь» (2008.10.08), «Баянхонгорын Баянлиг сумынхныг Хятадууд ундны усгүй болголоо» (2008.10.09), «Нийслэлийн хөлбөмбөгийн ганц талбай Хятадуудын мэдэлд очжээ» (2008.10.20) г. м. Хятадуудад буруу өгөх хэрэг байна уу? Хонгорыг хордуулсан хятадуудын хэрэг шийдэгдэхгүй, Баянхонгор аймгийн Баянлиг

сумыг ундны усгүй болгосон, нийслэлийн хөлбөмбөгийн ганц талбайг мэдэлдээ авсан бол хятадууд биш, монгол төрийн түшмэд буруутай. Хамаг бурууг хятадуудад тохсоноор ямар ч асуудал шийдэгдэхгүй. Учир нь тэднээс Монголын газар шороог хайрлахыг хүсэх нь утгагүй. Харин буруутны бурууг сэтгүүлч эрж хайх ёстой. Тэдэнд зөвшөөрөл олгож байгаа, тэдний талд шийдвэр гаргаж байгаа, тэднийг өөгшүүлж байгаа монгол эрхэм хэн бэ?

Ишлэл

¹ Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966, 141 дэх тал.

² Дамбажав И., Зундуй Л. Сонин гаргах урлаг. УБ., 1989, 76 дахь тал.

³ В а r d R. Newswriting Guide. Washington, 1993, p. 67.

⁴ К у л а к о в А. Н. Заголовок и его оформление в газете. Л., 1982, с. 30.

⁵ Б о г д а н о в Н. Г., В я з е м с к и й Б. А. Справочник журналиста. Л., 1971, с. 420.

⁶ К о х а н о в а Л. А. Экологический PR: составные профессии. М., 2004, с. 158.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. А р и у н Л. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ., 2008.

2. Д а м б а ж а в И., З у н д у й Л. 1989. Сонин гаргах урлаг. УБ.

3. Ц э в э л Я. 1966. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.

4. Ч о й с а м б а Ч. 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.

5. Б е р л о в а О. 1998. Некоторые аспекты экологических публичных рилейшнз в России. Tacis.

6. Б о г д а н о в Н. Г., В я з е м с к и й Б. А. 1971. Справочник журналиста. Л.

7. К о х а н о в а Л. А. 2004. Экологический PR: составные профессии. М.

8. К у л а к о в А. Н. 1982. Заголовок и его оформление в газете. Л.

9. Ф р и д м а н Ш. М., Ф р и д м а н К. А. 1998. Пособие по экологической журналистике. Tacis.

10. В а r d R. 1993. Newswriting Guide. Washington.

Резюме

В настоящей статье автор на основании анализа заголовков газетных публикаций на экологическую тему предпринял попытку классифицировать наиболее часто встречаемые стилистические, фактологические и логические ошибки и недочёты. Согласно мнению автора, к таковым относятся использование недостоверных источников информации, всезнайство, сухое перечисление или преднамеренное гипертрофирование фактов и т. д. Кроме того, автор на конкретных примерах показал, какие заголовки наиболее идеально подходят для экологических публикаций.